



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/363

Булган сум

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.17, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Бугат, Орхон, Сэлэнгэ, Хангал сумдын 2020-2024 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгосон газар олголтыг шалгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

О.Ундрах (аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

Г.Давааням (аймгийн Засаг даргын Тамгын

газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Г.Гантулга (аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

С.Наранбаатар (аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга)

С.Амар (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

М.Одбаяр (аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Геодези зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Х.Энхбаяр (аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газар, геодези зураг зүйн хяналтын улсын байцаагч)

2.Дээрх сумдын газар олголтыг хууль журмын хүрээнд олгосон эсэхэд хяналт шалгалтыг 2025 оны 05 дугаар сарын 30-наас 06 дугаар сарын 14-ний хооронд зохион байгуулж, үр дүнг аймгийн Засаг даргад тайлагнахыг ажлын хэсэг (О.Ундрах)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010504